

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

( 2013 оны эхний хагас жилд )

**I. ТӨСӨВ:** 2013 оны 1-р сарын 1-нээс “Төсвийн тухай хууль” шинээр хэрэгжиж эхэлснээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, соёлын байгууллагууд, хүүхэд гэр бүлийн хэлтэс, газрын алба, халамж асрамжийн үйлчилгээ зэрэг зардлууд орон нутгийн төсвөөс санхүүжих болсонтой холбоотойгоор төсвийн зардал ихээр нэмэгдэж байна.

Мөн орлогын хувьд орон нутагт төвлөрдөг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг болсон. Дээр нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулдаг болсон.

Аймгийн төсвийн орлогод 26.6 тэрбум төгрөг орж, төлөвлөгөөгөө 3.3 хувиар давуулан биелээд байна

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 21.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Эхний хагас жилд 3.4 тэрбум төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 7.9 дахин их байна.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хас, Хадгаламж, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 57.8 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 10.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 30,4 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 5.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 84.9 хувь болох 844.3 мянган эх мал төллөж, гарсан төлийн 98.8 хувь болох 843.8 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 90.8 мянган толгойгоор дээгүүр байна.

Оны эхний малын 0.9 хувь болох 20.7 мянган том мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.1 хувьтай байна.

Хорогдлын 48 хувийг ямаа, 41.2 хувийг хонь эзлэж байна. Мөнххаан, Баруун-Урт, Асгат, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумдад оны эхний малын 0.9-5.7 хувь нь хорогдоод байгаа нь бусад сумдаасаа өндөр байна.

**Тариалалт:** 300 га-д үр тариа, 35 га-д техникийн ургамал, 66.9 га-д төмс, 24.9 га-д хүнсний ногоо тариалсан нь өнгөрсөн оны мөн үеэс тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна. Харин тэжээлийн ургамал 38.7 га-д тариалсан нь өнгөрсөн оны мөн үеэс 8.5 хувь буюу 3.6 га-гаар бага байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 15.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.7 тэрбум төгрөгөөр буюу 10.2 хувиар доогуур байна.

Оны үнээр 61.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 0.5 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс нарийн боов, дулаан, яндан, пийшин, шургуулга, түлээний авдар, угаалтуур, хогийн утгуур, савар, агааржуулагч, галын хайч, хантааз, сандал, хаалганы үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна. Энэ сард домбо, бурханы гунгарваа, тамганы гэрийг шинээр үйлдвэрлэсэн.

**V. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО:** Барилга: Эхний хагас жилийн байдлаар барилга угсралт, их засварын ажил 6351.4 сая төгрөг болж, 207.4 сая төгрөг буюу 3.3 хувь нь өөрийн аймгийн, 6144.0 төгрөг буюу 96.7 хувь нь гадны барилгын байгууллагуудад ноогдож байна. Барилга угсралт, их засварын ажил өнгөрсөн оны мөн үеэс 292.7 сая төгрөг буюу 4.4 хувиар буурчээ.

**Тээвэр:** Тээвэр бүхий байгууллагууд 32.2 сая.тн.км-ийн ачаа эргэлт, 15.8 сая.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж, 4.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

**Холбоо:** Холбооны ашиглалтын орлого 228.8 сая төгрөгт хүрсний дотор 80.8 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 784 байна.

Боловсролын үйлчилгээ, холбооны үнэ, тариф жилийн эцэст байсан хэмжээндээ тогтвортой байна.

**VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний үнийн индекс 6-р сард өмнөх 2012 оны жилийн эцсийнхээс 3.8 хувиар өслөө. Энэхүү өсөлтийн цаана хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 8.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 5.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 3.7 хувь, тээврийн бүлгийн үнэ 2.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 4.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 8.7 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 4.9 хувиар тус тус өссөн байна.

**VII. СОЁЛ, БОЛОВСРОЛ:** **Соёл:** Хөгжимт жүжигийн театр нь эхний хагас жилд 11.5 үзэгчдэд 34 тоглолтоор үйлчилсний 9 нь өөрийн байранд, 25 нь алсын бригадын аялан тоглолт хийсэн байна. Нийт тавьсан тоглолтын 35.3 хувь нь жүжиг, 64.7 нь концерт байна. Алсын бригадын орлогын тооцоо хийгдээгүй учир театрын орлогын дүн 1-р улирлын байдлаар тавигдлаа.

**Музей:** 2.0 мянган үзмэрээр 1.3 мянган хүнд үйлчилж, 883.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

**Нийтийн номын сан:** 15.0 мянган уншигчдад 44.7 мянган номоор үйлчилсэн байна.

**Боловсрол:** ЕБС-ийн 2012-2013 оны хичээлийн жилд 3068 хүүхэд төгссөний дотор 678 хүүхэд бүрэн дунд боловсролыг, 1066 хүүхэд суурь боловсролыг, 1324 хүүхэд бага боловсролыг тус тус эзэмшсэн байна.

**VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ:** Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3.9 тэрбум төгрөг болж төлөвлөгөөгөө 6.5 хувиар давж биелэв. Сайн дурын даатгуулагчид 127.2 сая төгрөгний шимтгэл оруулсан байна. 6269 өндөр настанд 7.2 тэрбум төгрөгийн тэтгэвэрийг бүрэн олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 0.9 тэрбум төгрөгийг 4.6 мянган иргэнд, улсын төсвөөс 1.1 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 6.6 мянган иргэнд олгосоны дотор хүний хөгжил сангаас 79.6 сая төгрөгийг 85 иргэнд тус тус олгосон байна.

**IX. ЭРҮҮЛ МЭНД:** Эхний хагас жилд 597 эх амаржиж, 603 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр 634 хүн өвчилсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 282-ээр олон байгаа бөгөөд гахай хавдар, тэмбүү, салхинцэцэг, сүрьеэ, заг зэрэг өвчлөлүүд өссөн байна.

**X. АЖИЛГҮЙЧҮҮД:** Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 901 болж, өнгөрсөн оны мөн үеэс 7-н хүнээр буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 61.2 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 18.9 хувь нь дээд, 6.9 хувь нь тусгай дунд, 41.8 хувь нь бүрэн дунд, 6.6 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний хагас жилд 1160 хүн шинээр бүртгүүлж, 385 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 248 хүн ажиллаж байна.

**XI. ГЭМТ ХЭРЭГ:** Эхний хагас жилд 142 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 28-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 13 хүн нас барж, 62 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 367.1 сая төгрөгийн хохирол учирсны 83.7 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 150 хүн холбогдон сэжиглэгдсэний 35.3 хувь нь согтуугаар, 21.3 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1355 хүн эрүүлжигдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 545 хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 137 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

**XII. МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ:** Энэ онд 13 суманд 4 даатгалын нэгжийн 121 төлөөлөгч эрхээ аваад ажиллаж байна.

**XIII. ДААТГАЛ:** Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 232.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 6.6 хувиар өссөн байна. 274 хүнд 27.5 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосоны дотор авто тээврийн

хэрэгсэлд 1.8 сая, гэнэтийн осолд 2.1 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 4.1 сая, жолоочийн хариуцлагад 15.1 сая, иргэний эд хөрөнгөд 3.2 сая, хүүхдийн гэнэтийн осолд, гэр хашаа байшинд 0.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалд 1 сая төгрөгийг тус тус олгожээ.

**XIV. ТӨСӨЛ: ЖДҮДСан:** Аймгийн хэмжээгээр жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөлд хамрагдахаар 1.8 тэрбум төгрөгийн 51 төслийг иргэд ирүүлснээс 433.0 сая төгрөгний 15 төсөл шалгаран батлагдаж санхүүжилтээ авсан нь өнгөрсөн онтой харьцуулахад төслийн тоо 60 хувиар, санхүүжилт нь 45.1 хувиар тус тус буурчээ.

**XV. ГАЗАР ӨМЧЛӨЛ:** Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 7020 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 6691 иргэнд 619.31 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байгаагийн дотор эхний хагас жилд 134 иргэн өргөдөл гаргаж, 7.15 га газрыг өмчлүүлэх шийдвэрээ гаргуулсан байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС